

БАТЛАВ;  
ЗАСАГ ДАРГА Ч.ШОШДАР  
НӨМРӨГ СУМЫН БАЯНЗҮРХ БАГТ БАГИЙН ТӨВ БАРИХ АЖЛЫН  
ДААЛГАВАР

2024-08-05

Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана.

Ажлын зураг, өртгийн төсвийг тухайн салбарын дүрэм журмыг үндэслэн боловсруулж холбогдох зардлын хувь хэмжээг нарийн заасан байх

1. **Багийн төвийн хэмжээ** 10x12 харьцаатай байна
2. **Барилгын суурь** :Газрын гадаргаас доош 20 см, дээш 20 см -с дээш бетонон суурьтай байна.
3. Бүс бетоной байна
4. **Барилгын хана**: Таазнаас шал хүртэлх өндөр 2,8 метр, Палкаар өрж дотор гадна талыг шавардсан байна
5. **Барилгын дотор тасалгаа** :Багийн даргын өрөө 3x3, Эмчийн өрөө 3x3, Хурлын заал 9x7
6. **Дотор засал**: Таазыг 60x60 хэмжээтэй дүүзэн тааз угсарна.Дотор рамыг зангидаж гипсэн хавтангаар өнгөлж 2 үе замаскан тэгшилгээ хийж тосон будгаар будна
7. **Хаалга цонх**: Цонх цагаан өнгийн хуванцар рамтай тунгалаг өнгийн давхар шилтэй вакум цонх байна. Цонх 1,5x1,5 см хэмжээтэй цонх 3 ш, 1,2x1,2 см хэмжээтэй цонх 2 ш, Дотор тасалгаанд 2 ширхэг модон хаалга, гадна хаалга бүргэд хаалга хийсэн байна. Хаалга цонх нь Монгол Улсад мөрдөж буй норм стандарт дулаан техникийн шаардлагыг хангасан байна.
8. **Дээвэр**: А нуруу буюу шувуу нурууг 50x150 мм банзаар холбоос бэхэлгээг сайтар зангидаж хийнэ .Модон хучилтын дээр уур ус тусгаарлагч болон 100 мм зузаан эрдэс хөвөн дулаалга хийнэ.Шувуу нурууг хийсний дараа 25 мм - н зузаан банзаар нурууг хучиж долгионт тамраар дээвэрлэнэ. Бүх модон материалыг галаас хамгаалах түхлэг 2 үе хийж өгнө.
9. **Шал**:Халаалтын зуух пийшин тавих хэсэгт 2x2 м хэмжээтэй керамик хавтан шал, бусад хэсэгт дулаалгатай паркетин шал байна.
10. **Гэрэлтүүлэг**: Өрөө тус бүрт гэрэл гэрлийн унтраалга, раетка хийнэ.

11. **Гадна тохижилт:** Барилгын гадна барилгын бүтэн тойрсон хайс хамгаалалт хийж , авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээ хийж өгнө
12. Гадна ОО -тай байна
13. **Гадна үүд:** Цементен довжоотой 2х2 харьцаатай төмөр сүүдрэвчтэй байна.
14. **Бусад шаардлага:** Барилга барих угсралтын ажлын холбогдох норм дүрэм заалтыг мөрдлөгө болгон ажиллах шаардлагатай
15. Барилгыг барих материал татан авалт болон барилгын үе шатны ажлын үйл явц бүрийг фото зургаар баталгаажуулан ажлын тайланд ирүүлж байж санхүүжилт олгоно.

Хуучин багийн төвийн барилгаас ашиглаж болох материалыг ашиглаж барьж болох ба хуучин багийн төвийг нураасан хаягдал материалыг хогийн цэгт ачиж буулгаж орчныг нь цэвэрлэнэ.